

**ХҮҮХДИЙН ЭРХИЙН УЛСЫН БАЙЦААГЧИЙН АЖИЛЛАХ ДҮРЭМ****НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ****Нэг. Дүрмийн зорилго**

1.1.Энэ дүрмийн зорилго нь хүүхдийн эрхийн улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагчаас /цаашид тухайлан нэрлэснээс бусад тохиолдолд “хүүхдийн эрхийн улсын байцагч” гэх/ хяналт шалгалт хийх, бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2.Хүүхдийн эрхийн улсын байцаагч үйл ажиллагаандаа Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.19-д заасны дагуу Засгийн газраас баталсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”, энэ дүрмийг удирдлага болгоно.

**Хоёр. Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн баримтлах зарчим**

2.1.Хүүхдийн эрхийн улсын байцаагч үйл ажиллагаандаа Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйл, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмаас гадна хүүхдийн хувийн болон эмзэг мэдээллийг үл задруулах, хууль дээдлэх, хараат бус, хөндлөнгийн нөлөөлөл, ашиг сонихлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтална.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ  
ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХЯНАЛТЫН ЗОРИЛГО, ЧИГЛЭЛ****Гурав. Хүүхдийн эрхийн хяналтын зорилго**

3.1.Хүүхдийн эрхийн хяналтын зорилго нь хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхтэй холбоотой зөрчил дутагдлыг илрүүлэх, таслан зогсоох, арилгуулах замаар хүүхдийн эрхийг хангахад оршино.

**Дөрөв. Хүүхдийн эрхийн хяналтын чиглэл**

4.1.Хүүхдийн эрхийн улсын байцаагч энэ дүрмийн 3.1-д заасан зорилгыг биелүүлэх хүрээнд хүүхдийн эрхийн хяналтыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ:

4.1.1.хүүхдийн эрхийн талаарх хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт, стандартын хэрэгжилт;

4.1.2.хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт;

4.1.3.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан дүрэм, заавар, аргачлалын хэрэгжилт;

4.1.4.хүүхдийн эрхийн улсын ерөнхий байцаагчаас гаргасан албан даалгаврын хэрэгжилт;

4.1.5.нэг цэгийн үйлчилгээ, түр хамгаалах байрны үйл ажиллагаа, ашиглалт;

4.1.6.хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ болон хүүхэд харах үйлчилгээ дэх хүүхдийн эрх, хамгааллын асуудал;

4.1.7.хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх төр, орон нутгийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа этгээдийн үйл ажиллагаа, гэрээний биелэлт, олгосон санхүүжилтийн зарцуулалт;

4.1.8.хүүхдийн эрхийн асуудлаар төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан болон хүүхдийн тусламжийн 108 утсаар ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн байдал;

4.1.9.боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төв, сүм хийдийн үйл ажиллагаа, дотуур байр дахь хүүхдийн эрх, хамгааллын асуудал;

4.1.10.боловсролын сургалтын байгууллагаас гадуурх сургалтын ажил эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа дахь хүүхдийн эрх, хамгааллын асуудал;

4.1.11.эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх, хамгааллын асуудал;

4.1.12.хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхдийн эрх, хамгааллын асуудал;

4.1.13.худалдаа, үйлчилгээ, олон нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал, цуглаан, замын хөдөлгөөн, шалгалт, уралдаан тэмцээний үеийн хүүхдийн эрх, хамгааллын асуудал;

4.1.14.соёл, спортын үйл ажиллагаа, спортын тэмцээн, үндэсний спорт, урлагийн тоглолт, бусад арга хэмжээ дэх хүүхдийн эрх, хамгааллын асуудал

4.1.15.хүүхдийн тоглоомын талбай, хурдан морь уралдах зам талбайн аюулгүй байдал;

4.1.16.гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үеийн хүүхдийн эрх, хамгааллын асуудал;

4.1.17.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхдийн эрх, хамгааллын асуудал;

4.1.18.сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байгаа хүүхдийн эрх, хамгааллын асуудал;

4.1.19.хүүхдээр хөдөлмөр эрхлүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн харилцаанд хүүхдийн эрх зөрчигдөж байгаа эсэхэд хяналт тавих;

4.1.20. 15 нас хүрээгүй хүнийг урлаг, спортын үзүүлбэр, зар сурталчилгаанд оролцуулах зөвшөөрөл олгох;

4.1.21.хүүхдийг үрчлүүлэх үйл ажиллагаанд хүүхдийн эрх зөрчигдөж байгаа эсэхэд болон үрчлэгдсэн хүүхдийн эрхийн хэрэгжилтэд хяналт тавих;

4.1.22.хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх үйл ажиллагаа, түүний бүртгэл, хөтлөлт, хилийн чанад дахь Монгол Улсын харьяат хүүхдийн эрх, хамгааллын асуудал;

4.1.23.хүүхдийн эсрэг болон хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж эрүүгийн хариуцлага хүлээсэн хүнийг хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг байгууллагад ажиллуулах, хүүхэдтэй холбоотой ажил, үүрэг гүйцэтгүүлж байгаа эсэх;

4.1.24.хүүхэд тусламж, үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдсэн хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт, стандартын хэрэгжилтийг хариуцсан төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд үнэлэлт өгч дүгнэлт, зөвлөмж гаргах;

4.1.25.хууль тогтоомжид заасан бусад.

4.2.Хүүхдийн эрхийн улсын байцаагч холбогдох хууль, энэ дүрмээр өөрт нь ногдуулсан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хяналт шалгалтын бусад байгууллагатай хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулна.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ УЛСЫН БАЙЦААГЧИЙН ЭРХ ОЛГОХ, ЦУЦЛАХ, УЛСЫН БАЙЦААГЧИЙГ СУРГАХ**

### **Тав. Улсын байцаагчийн эрх олгох, цуцлах**

5.1.Улсын хэмжээнд хүүхдийн улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагчид ажиллана.

5.2.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хүүхдийн эрхийн улсын ерөнхий байцаагч /цаашид “улсын ерөнхий байцаагч” гэх/ байна.

5.3.Улсын ерөнхий байцаагч улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг олгох, цуцлах асуудлыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.5-д заасны дагуу Засгийн газраас баталсан журмын дагуу шийдвэрлэнэ.

5.4.Хүүхдийн эрхийн улсын байцаагч Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.8-д заасны дагуу Засгийн газраас загварыг нь баталсан албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг хэрэглэнэ.

### **Зургаа. Улсын байцаагчийг сургах, мэргэшүүлэх**

6.1.Улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрх олгох ажилтан нь Хүүхдийн эрхийн тухай хуулийн 20.2-т заасны дагуу хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байна.

6.2.Улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг улсын ерөнхий байцаагчаас баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу мэргэшүүлэх, давтан сургалтад хамруулна.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮҮХДИЙН ЭРХИЙН УЛСЫН БАЙЦААГЧИЙН БҮРЭН ЭРХ**

### **Долоо. Улсын байцаагчийн бүрэн эх**

7.1. Улсын байцаагч Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9, Хүүхэд хамгааллы тухай хуулийн 55.2-т зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. хүүхэд аюултай нөхцөл байдалд орсон тохиолдолд аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламж, ажлын байр, орон байранд урьдчилан мэдэгдэхгүйгээр чөлөөтэй нэвтэрч хүүхдийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах;

7.1.2. энэ дүрмийн 7.1.2-т зааснаас бусад тохиолдолд хяналт шалгалтыг улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагчаас баталсан удирдамжийн дагуу гүйцэтгэх;

7.1.3. хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр, хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн, өртөх эрсдэлтэй хүүхдийг илрүүлэх, холбон зуучлах арга хэмжээ авах;

7.1.4. хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх зорилгоор хүүхдийн гэр бүл, сургалтын орчинтой танилцах, хүүхэд болон бусад холбогдох иргэн, албан хаагчтай ярилцлага хийх, асуулга авах;

7.1.5. хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учирсан буюу учруулж болзошгүй нь зохих ёсоор нотлогдсон тохиолдолд худалдаа, үйлчилгээ, олон нийтийг хамарсан арга хэмжээ, соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, спортын тэмцээн, үндэсний спорт, жагсаал, цуглаан, бусад арга хэмжээг уг зөрчлийг арилгах хүртэл хугацаанд бүхэлд нь эсхүл хэсэгчлэн түр зогсоох арга хэмжээ авах;

7.1.6. хүүхдийн хэвийн өсөлт, хөгжил, эрүүл мэнд, аюулгүй байдалд хор хохирол учруулах байдлаар үйл ажиллагаа явуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгосон зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулдаг тохиолдолд үйл ажиллагааг нь хязгаарлах, зогсоох талаар дүгнэлт гаргаж эрх бүхий этгээдэд хүргүүлэх;

7.1.7. хяналт шалгалтад мэргэжлийн хүн, хуулийн этгээдийг оролцуулах, шаардлагатай асуудлыг магадлах, дүгнэлт гаргуулах саналаа улсын ахлах байцаагч, улсын ерөнхий байцаагчид уламжлах;

7.1.8. хүүхдийн эрхийн тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулах, хүн, хуулийн этгээдэд хүүхдийн эрхийн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, зөвлөн туслах;

7.1.9. өөрийн харьяалан шийдвэрлэх зөрчилд хамаарахгүй зөрчлийн шинжтэй асуудлыг харьяалах байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх.

### **Найм. Улсын ахлах байцаагчийн бүрэн эрх**

8.1.Улсын ахлах байцаагч Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.12, энэ дүрмийн 7.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

8.1.1.улсын байцаагчийн үйл ажиллагаанд хуульд заасны дагуу хяналт тавих;

8.1.2.улсын байцаагчийн шийдвэрийг эс зөвшөөрч холбогдох этгээдээс гаргасан гомдлыг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх;

8.1.3.доод шатныхаа улсын байцаагчийн эрхийг цуцлах, улсын ахлах байцаагчийн эрх олгох тухай саналыг улсын ерөнхий байцаагчид уламжлах;

8.1.4.харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд хор хөнөөл учруулж болзошгүй хүчин зүйл байгаа эсэх, түүний шалтгааныг тодорхойлох, учрах эрсдэлийг хянах, бууруулах зорилгоор тандалт судалгаа, хяналт шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах.

### **Ес. Улсын ерөнхий байцаагчийн бүрэн эрх**

9.1.Улсын ерөнхий байцаагч Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.12-т зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1.хүүхдийн эрхийн чиглэлээр хэрэгжүүлэх хяналт шалгалтын объект, хяналт шалгалт хийх нарийвчилсан чиглэлийг батлах;

9.1.2.улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг олгох, цуцлах;

9.1.3.хүүхдийн эрхийн талаарх хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх, цаг үеийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор албан даалгавар гаргах;

9.1.4.хүүхдийн эрхийн асуудлаар нийтлэг зөвлөмж гаргах;

9.1.5.хяналтын хуудас батлах;

9.1.6.улсын ахлах байцаагчийн шийдвэрийг эс зөвшөөрч гаргасан гомдлыг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх;

9.1.7.хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд хор хөнөөл учруулж болзошгүй хүчин зүйл байгаа эсэх, түүний шалтгааныг тодорхойлох, учрах эрсдэлийг хянах, бууруулах зорилгоор тандалт судалгаа, хяналт шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах.

### **Арав. Ажил тайлагнах, танилцуулах**

10.1.Улсын байцаагч улсын ахлах байцаагчид, улсын ахлах байцаагч улсын ерөнхий байцаагчийн өмнө тус тус ажлаа хариуцна.

10.2.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дахь салбарын улсын ерөнхий байцаагч нь улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

10.3.Улсын ахлах байцаагч нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд хамаарах хүүхдийн эрхийн зөрчлийн хэрэг бүртгэлт, хэрэгжүүлсэн хяналт шалган дүн, мэдээллийг хагас жил бүрээр гаргаж тухайн шатны Хүүхдийн төлөө орон нутгийн зөвлөл болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлнэ.

10.4.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын салбарын хяналт хариуцсан нэгж улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн хагас болон бүтэн жилийн тайланг нэгтгэн улсын ерөнхий байцаагчид танилцуулна.

10.5.Улсын ерөнхий байцаагч хүүхдийн эрхийн зөрчлийн хэрэг бүртгэлт, хэрэгжүүлсэн хяналт шалган дүн, мэдээллийг жил бүр Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж, олон нийтэд мэдээлнэ.

## **ТАВДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ**

### **Арван нэг. Хяналтын шалгалтын төрөл**

11.1.Хүүхдийн эрхийн улсын байцаагч Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу хяналт шалгалтыг дараах төрлөөр хийнэ:

- 11.1.1.төлөвлөгөөт хяналт шалгалт;
- 11.1.2.төлөвлөгөөт бус хяналт шалгалт;
- 11.1.3.урьдчилан сэргийлэх хяналт шалгалт;
- 11.1.4.гүйцэтгэлийн шалгалт.

11.2.Хүүхдийн эрхийн улсын байцаагч хяналт шалгалт хийхээс өмнө хяналт шалгалтын удирдамжийг Засгийн газраас баталсан "Хяналт шалгалт хийх нийтлэг журам"-д заасны дагуу батлуулсан байна.

11.3.Хүүхдийн эрхийн улсын байцаагч хяналт шалгалт хийх тухайгаа хуульд заасан хугацаанд шалгуулагч этгээдэд мэдэгдэх хуудсаар шуудангаар, утсаар, биечлэн урьдчилан мэдэгдэнэ. Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тохиолдолд урьдчилан мэдэгдсэн байхыг шаардахгүй.

### **Арван хоёр. Төлөвлөгөөт хяналт шалгалт**

12.1.Улсын ерөнхий байцаагч хүүхдийн эрхийн чиглэлээр хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5<sup>1.2</sup>-т заасны дагуу Засгийн газраас батлах салбарын хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгаж батлуулна.

12.2.Улсын ерөнхий байцаагч энэ дүрмийн 3.1-д заасны дагуу батлагдсан хяналт шалгалтын төлөвлөгөөнд нийцүүлэн хүүхдийн эрхийн чиглэлээр хийх хяналт шалгалтад хамрагдах объект, хяналт шалгалт хийх нарийвчилсан чиглэлийг батална.

### **Арван гурав. Төлөвлөгөөт бус хяналт шалгалт**

13.1.Хүүхдий эрхийн улсын байцаагч төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг дараах үндэслэлээр хийнэ:

13.1.1.өөрийн санаачилгаар;

13.1.2.хүүхдийн эрхийн зөрчлийн тааар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас үндэслэл бүхий өргөдөл, гомдол, мэдээлэл ирүүлсэн;

13.1.3.хяналт шалгалт хийх талаар дээд шатны байгууллага, албан тушаалтнаас бичгээр үүрэг даалгавар өгсөн;

13.1.4.хуульд заасан бусад үндэслэл.

### **Арван дөрөв. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт**

14.1.Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учрах, хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор хийнэ.

14.2.Худалдаа, үйлчилгээ, олон нийтийг хамарсан арга хэмжээ, соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, спортын тэмцээн, үндэсний спорт, жагсаал, цуглаан, бусад арга хэмжээ эхлэхээс өмнө урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж болно.

14.3.Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг тухайн асуудлыг хариуцсан хяналт шалгалтын байгууллагатай хамтран хийж болно.

### **Арван тав. Гүйцэтгэлийн шалгалт**

15.1.Гүйцэтгэлийн шалгалтыг өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах талаар улсын байцаагчаас өгсөн албан шаардлагын биелэлтийг хянах, хангуулах зорилгоор хийнэ.

## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ ХҮҮХДИЙН ЭРХИЙН УЛСЫН БАЙЦААГЧААС ГАРГАХ ШИЙДВЭР, ТҮҮНД ГОМДОЛ ГАРГАХ**

### **Арван зургаа. Хүүхдийн эрхийн улсын байцаагчаас гаргах шийдвэр**

16.1.Хүүхдийн эрхийн улсын байцаагч хяналт шалгалтын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Засгийн газраас баталсан "Хяналт шалгалт хийх нийтлэг журам", "Хяналт шалгалтын баримт бичгийн загвар"-ын дагуу хяналт шалгалтын удирдамж, хяналт шалгалтын танилцуулга, шалгалтын тэмдэглэл, хяналтын хуудас, мэдэгдэх хуудас, албан шаардлага, зөвлөмж, дүгнэлт, акт үйлдэнэ.

16.2.Хүүхдийн эрхийн улсын байцаагч хүүхдийн эрхийн тухай хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт, стандарт зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг зөрчиж болзошгүй шалтгаан нөхцөлийг арилгуулах зорилгоор зөвлөмж үйлдэнэ.

16.3.Хүүхдийн эрхийн улсын байцаагч хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох, залруулах, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар хугацаатай албан шаардлага үйлдэнэ.

16.4. Хүүхдийн эрхийн улсын байцаагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгосон зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, үйл ажиллагааг нь хязгаарлах, зогсоох, холбогдох этгээдийг эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах талаар эрх бүхий этгээдэд санал хүргүүлэх, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт, стандарт шаардлагыг хангаж байгаа эсэхийг тодорхойлоход дүгнэлт үйлдэнэ.

16.5. Хүүхдийн эрхийн улсын байцаагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг улсын орлого болгох, хүүхдэд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох, актын үйлчлэлийг дуусгавар болгож, үйл ажиллагааг сэргээх тохиолдолд акт үйлдэнэ.

16.6. Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн гаргах шийдвэр нь Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

### **Арван долоо. Гомдол гаргах**

17.1. Холбогдох этгээд улсын байцаагчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл улсын ахлах байцаагчид, улсын ахлах байцаагчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл улсын ерөнхий байцаагчид Захиргааны ерөнхий хуульд заасан хугацаанд гомдол гаргах эрхтэй.

17.2. Улсын ерөнхий байцаагч, Улсын ахлах байцаагч энэ дүрмийн 17.1-д заасан гомдлыг Захиргааны ерөнхий хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлэж, хариу өгнө. Хэрэв гомдол гаргагч уг шийдвэрийг эс зөвшөөрвөл хуульд заасны дагуу шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

## **ДОЛООДУГААР БҮЛЭГ БУСАД ЗААЛТ**

### **Арван найм. Улсын байцаагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгаа**

18.1. Хүүхдийн эрхийн улсын байцаагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 11.1-д заасан баталгаагаар хангагдана.

18.2. Хүүхдийн эрхийн улсын байцаагч хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хяналт шалгалт хийхэд иргэн, хуулийн этгээдээс хүч хэрэглэж, эсхүл зохион байгуулалттайгаар эсэргүүцэл үзүүлсэн тохиолдолд тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага туслалцаа үзүүлж, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авна.

18.3. Хүүхдийн эрхийн улсын байцаагчаас цахим орчинд хүүхдийн эрхийг зөрчсөн, хүүхдийг урхидсан, дээрэлхсэн, дарамталсан этгээдийг олж тогтоох, шаардлагатай ажиллагааг явуулахад цагдаагийн байгууллага туслалцаа үзүүлнэ.

18.4. Хүүхдийн эрхийн улсын байцаагч хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчинд хориотой агуулгыг хаах, хүүхдэд хортой агуулгыг хянах, хязгаарлах, хаах арга хэмжээ авахад Харилцаа холбооны зохицуулах хороо, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч, холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллана.



18.5.Хүүхдийн эрхийн улсын байцаагчаас хилийн чанад дахь Монгол Улсын харьяат хүүхдийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулахад гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн улс дахь Элчин сайдын яам, Консулын газар туслалцаа үзүүлнэ.

### **Арван ес. Хүүхдийн эрхийн төлөөллийг хэрэгжүүлэх**

19.1.Хүүхдийн эрхийн улсын байцаагч хүүхдийн эрх зөрчигдсөн гэж үзвэл хуульд заасан журмын дагуу төрийн байгууллагад өргөдөл, гомдол, шүүхэд нэхэмжлэл гаргах замаар хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонихлыг хамгаалж ажиллана.

19.2.Хүүхдийн эрхийн улсын байцаагч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр оролцож, хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тууштай хамгаалан ажиллана.

19.3.Хүүхдийн эрхийн улсын байцаагч гэр бүлээсээ тусгаарлагдаж хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн хөрөнгө, өвлөгдөх хөрөнгөд эрхлэн хамгаалалт тогтоолгох тухай хүсэлт, нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянаан шийдвэрлэх тухай хуулийн 135 дугаар зүйлийн 135.2.11-д заасны дагуу шүүхэд гаргаж шийдвэрлүүлнэ.

### **Хорь. Хариуцлага**

20.1.Энэ дүрмийг зөрчсөн улсын байцаагчийн эрхий цуцажл, хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---ooOOoo---